

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**“МОНГОЛ ЛЗ ЗАМ ГҮҮР ХХК” -ИЙН
ХООРОНД БАЙГУУЛСАН**

**“ТОСОНЦЭНГЭЛИЙН 4 ЗАМЫН УУЛЗВАР-НӨМРӨГ-СОНГИНО ЧИГЛЭЛИЙН
167 КМ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН БАРИХ–ШИЛЖҮҮЛЭХ (ВТ)
КОНЦЕССЫН ГЭРЭЭ**

**УЛААНБААТАР ХОТ
2016 ОНЫ 7 ДУГААР САРЫН 19-НЫ ӨДӨР**

ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**
Нэр томъёоны тодорхойлолт
Гэрээний тайлбар
Концессын зүйл
Концессын төрөл
Концессын зүйлд тавигдах шаардлага
Гэрээний үнэ
Концессын зүйлийг ашиглалтад оруулах хугацаа
Баталгаат хугацаа
Хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарь
Концессын гэрээний хугацаа
Гэрээ хүчин төгөлдөр болох
Концессын зүйлийг шилжүүлэх үед тавигдах шаардлага

ХОЁРДУГААР БҮЛЭГ

КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

Эрх бүхий этгээдийн эрх, үүрэг
Зохицуулах байгууллагын эрх, үүрэг
Концесс эзэмшигчийн эрх, үүрэг

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАРИЛГЫН АЖИЛ, ЗАСВАР АРЧЛАЛТ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

Чанарын хяналт
Даатгал

ТАВДУГААР БҮЛЭГ

ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Мэдэгдэл
Давагдашгүй хүчин зүйл дуусгавар болох
Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг өөрчлөх, цуцлах

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

КОНЦЕССЫН ГЭРЭЭГ СУНГАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ХАРИУЦЛАГА

ДОЛООДУГААР БҮЛЭГ

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлын 2009 оны "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64, 2012 оны "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 37 дугаар тогтоол, Концессын тухай хууль, Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 226 дугаар тогтоолыг тус тус **ҮНДЭСЛЭН**:

НЭГ ТАЛААС

"Монгол Улсын Засгийн газар"-ыг төлөөлж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалтын газар "цаашид Эрх бүхий этгээд" гэх;

НӨГӨӨ ТАЛААС

МОНГОЛ ЛЗ ЗАМ ГҮҮР ХХК -г төлөөлж ГҮЙЦЭТГЭХ захирал Жан Юун Зүнь /Zhang Yong Jun/ /цаашид "Концесс эзэмшигч" гэх/ концессын гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү Гэрээг байгуулав.

Энэхүү Гэрээний зорилго нь Монгол Улсын Засгийн газар, Эрх бүхий этгээд, зохицуулах байгууллага, концесс эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага, гүйцэтгэх ажил, хамрах хүрээ, эдлэх эрхийн хэмжээ, концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, дуусгавар болгох, цуцлах, концессын зүйлийг төрийн өмчид шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Нэр томъёоны тодорхойлолт

- 1.1. Энэхүү Концессын гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ.
 - 1.1.1. "Авто зам" гэж авто тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж сайжруулсан болон замын хөдөлгөөнд нээлттэй зурвас газрыг;
 - 1.1.2. "Замын байгууламж" гэж модон ба төмөр, төмөр бетон, чулуун бусад гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжийг;
 - 1.1.3. "Замын барилгын ажил" гэж авто зам, замын байгууламж түүний бүрэлдэхүүнийг барих, тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

- 1.1.4. "Зохицуулах байгууллага" гэж концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох, концессын зүйл, эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг;
- 1.1.5. "Зураг төсөл" гэж барилга байгууламжийг барих техникийн болон ажлын зураг, инженер-геологийн судалгааны дүгнэлт, геодезийн зураглал, барилга байгууламжийн өртгийн нэгдсэн төсвийг;
- 1.1.6. "Засвар арчлалт" гэж ашиглалтын хэвийн нөхцөл, найдвартай ажиллагааг хангах, ашиглалтын хугацаанаас өмнө элэгдэж эвдрэхээс хамгаалах, зориулалтаар нь зөв зохистой ашиглах, шаардлагатай засвар шинэчлэлийг цаг тухайд нь хийх үйл ажиллагааг;
- 1.1.7. "Барилгын ажлын гэрээ" гэж Концессын гэрээний урьдчилсан нөхцөлийн дагуу Концесс эзэмшигч болон Барилгын ажил гүйцэтгэгчийн хооронд магадлагдсан зураг төслийн дагуу, Барилгын ажил гүйцэтгэх тухай байгуулсан гэрээг;
- 1.1.8. "Концессын гэрээ" гэж Эрх бүхий этгээд болон концесс эзэмшигчийн хооронд байгуулсан энэхүү Гэрээг;
- 1.1.9. "Концесс эзэмшигч" гэж "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-г ;
- 1.1.10. "Талууд" гэж Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийг хамтад нь;
- 1.1.11. "Төслийн гүйцэтгэгч" гэж Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор аливаа үйл ажиллагаа эрхлэн явуулах, ханган нийлүүлэлт хийх, эсхүл үйлчилгээ үзүүлэх талаар Концесс эзэмшигчтэй гэрээ байгуулсан аливаа компани, хувь хүнийг;
- 1.1.12. "Санхүүжилтийн гэрээ" гэж Концесс эзэмшигч нь хөрөнгө оруулагч, зээл олгогчтой төсөлд оруулах хөрөнгө оруулалт болон эргэн төлөгдөх нөхцөл, концесс эзэмшигчид хувь нийлүүлэхээр тохиролцож байгуулсан гэрээг;
- 1.1.13. "Гүйцэтгэлийн баталгаа" гэж концесс эзэмшигч нь концессын гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүдийг биелүүлж чадна гэсэн санхүүгийн баталгааг;
- 1.1.14. "Комисс" гэж Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах комиссыг;
- 1.1.15. "Юань" гэж Бүгд найрамдах Хятад Ард Улсын улсын мөнгөн тэмдэгтийг;

Гэрээний тайлбар

- 1.2. Концессын гэрээний гарчиг нь зөвхөн хэрэглэхэд ойлгомжтой болгох зорилготой бөгөөд гэрээний агуулгыг тайлбарлахад нөлөөлөхгүй.

Концессын зүйл

- 1.3. Энэхүү Гэрээний концессын зүйл нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:
- 1.3.1. "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төсөл; /цаашид "авто зам" гэх/
 - 1.3.2. Замын байгууламж;
 - 1.3.3. Батлагдсан зураг төсөл байна.

Концессын төрөл

- 1.4. Энэхүү төсөл нь Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолд заасны дагуу концессын "БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ" төрөлтэй байна.

Концессын зүйлд тавигдах шаардлага

- 1.5. Концессын зүйл нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- 1.5.1. Авто замын зураг төсөл, техникийн шаардлагын дагуу баригдсан байх;
 - 1.5.2. Холбогдох хууль тогтоомжоор тавигддаг бусад шаардлагуудыг хангасан байх;
 - 1.5.3. Концесс эзэмшигч нь авто замын чанарыг сайжруулах, барилгын ажлын хугацааг богиносгох, ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор хяналтын зөвлөх компани болон зургийн зохиогчтой зөвшилцөн технологийн шаардлагыг өөрчлөх эрхтэй. Гэхдээ гэрээний үнэ өөрчлөгдөхгүй.

Гэрээний үнэ

- 1.6. Гэрээний үнэ буюу төслийн нийт хөрөнгө оруулалт нь **662,453,581** (зургаан зуун жаран хоёр сая дөрвөн зуун тавин гурван мянга таван зуун наян нэгэн) юаньтай тэнцэх төгрөг байна.

Концессын зүйлийг ашиглалтад оруулах хугацаа

- 1.7. Концесс эзэмшигч нь Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төслийг **2018 оны 10 дугаар сарын 31-ний** өдрөөс өмнө эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх хүсэлтээ гаргана. Эрх бүхий этгээд хүлээлгэн өгөх хүсэлтийг авснаас хойш 30 хоног дотор тус төслийн зүйлийг хүлээн авах үйл ажиллагааг эхлүүлэх ба Зам барилгын ажил болон ашиглалтад оруулах үйл ажиллагаа нь 2012 оны 12 сарын 01-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 151 тоот тогтоол болон үүний хавсралт болох "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу явагдана. Ашиглалтад тэнцүүлж хүлээн авсны дараа ажлын 15 хоногийн дотор шилжүүлсэн тухай баримт бичгийг үйлдэж холбогдох актыг Концесс эзэмшигчид олгоно. Тус төслийг Хүлээлгэн өгөхөөс өмнө, концесс эзэмшигч нь 100 хувь (газраас бусад) эзэмших эрхтэй, түүнчлэн төсөлтэй холбогдон гарч

болзошгүй эрсдэлийг хүлээх ба төслийг албан ёсоор хүлээлгэн өгөх хүртэл концесс эзэмшигч нь авто замыг эвдрэлээс хамгаалахын тулд замын хөдөлгөөнд нээхгүй байх эрхтэй. Төслийг засгийн газарт шилжүүлэх үед эд хөрөнгийн өмчлөх эрх болон эрсдэл даган шилжинэ. Гэвч концесс эзэмшигч нь гэрээний заалтын дагуу холбогдох үүргээ ялангуяа чанарын баталгааны хариуцлагын үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэсээр байна

Баталгаат хугацаа

- 1.8. Концессын зүйлийг концесс эзэмшигч нь ашиглалтад хүлээлгэн өгсөн өдрөөс хойш түүний баталгаат хугацаа **3 жил** байна.
- 1.9. Баталгаат хугацаан дахь төслийн авто замд технологийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд концесс эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж засварлах үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарь

- 1.10. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр санхүүжүүлэн, барьж дуусган холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээлгэн өгч, төсөлд оруулсан хөрөнгө оруулалтаа 4 жилийн хугацаанд Монгол улсын Засгийн газраас доорх хуваарийн дагуу нөхөж авна. Үүнд:

№	Төлбөрийн дүн /юань /	Төлбөрийн дүн /үсгээр/	Төлбөр гүйцэтгэх он сар өдөр
1	232,934,389	Хоёр зуун гучин хоёр сая есөн зуун гучин дөрвөн мянга гурван зуун наян есөн юань	2019 оны 3 сарын 31-ний өдрөөс өмнө
2	151,408,683	Нэг зуун тавин нэгэн сая дөрвөн зуун найман мянга зургаан зуун наян гурван юань	2020 оны 3 сарын 31-ний өдрөөс өмнө
3	143,173,064	Нэг зуун дөчин гурван сая нэг зуун далан гурван мянга жаран дөрвөн юань	2021 оны 3 сарын 31-ний өдрөөс өмнө
4	134,937,445	Нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун гучин долоон мянга дөрвөн зуун дөчин таван юань	2022 оны 3 сарын 31-ний өдрөөс өмнө

- 1.11. Энэхүү Гэрээний 1.10-т заасан эргэн төлөлтийг тухайн жилийн Улсын төсөвт тусгахдаа тухайн өдрийн Монгол банкны зарласан ханшаар хөрвүүлэн тооцно. Концесс эзэмшигчийн Хаан банк (AGMOMNUB) дахь доор дурдсан данс нь эргэн төлөлтийг шилжүүлэх батлагдсан данс байна. Монгол улсын засгийн газар энэхүү концессын гэрээний 1.10-д заасан хөрөнгө оруулалтын бүхий л эргэн төлөлтийг тус дансанд шилжүүлнэ.

Эзэмшигчийн нэр Монгол ЛЗ зам гүүр ХХК
Дансны дугаар 5116015546 /төгрөг/

Данс нээсэн банк Хаан банк (AGMOMNUB)

- 1.12. Энэхүү гэрээний 1.10-т заасан хуваарийн дагуу хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс эргэн төлөх өдрийн гадаад валютын ханшийн зөрүүнээс концесс эзэмшигчид ашиг гарах тохиолдолд дараагийн төлбөрөөс уг ашгийг хасаж тооцох ба хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс эргэн төлөх өдрийн гадаад валютын ханшийн зөрүүнээс концесс эзэмшигчид алдагдал гарах тохиолдолд уг алдагдлыг дараагийн төлбөрт нөхөж тусгана.
- 1.13. Концесс эзэмшигч нь эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөрөө аваагүй тохиолдолд энэхүү төлбөр нь Засгийн газрын өр болно.
- 1.14. Концесс эзэмшигч эргэн төлөлтийн хуваарийн дагуу нөхөн олговроо аваагүй тохиолдолд санхүүжүүлэгч талын баримтаар нэхэмжилсэн тохиолдолд алдангийн асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 1.15. “Хөрөнгө оруулалтын тухай” хуулийн 5-р зүйлд заасны дагуу концессын гэрээ нь хөрөнгө оруулалтын нэг хэлбэр болно.

Концессын гэрээний хугацаа

- 1.16. Энэхүү Гэрээний хугацаа талууд Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш **6 жил** байна.

Гэрээ хүчин төгөлдөр болох

- 1.17. Гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс гэрээ байгуулагдсанд тооцох бөгөөд концесс эзэмшигч нь санхүүгийн хаалтын баталгаа болох 1 /нэг/ тэрбум төгрөгийг 6 сарын хүчинтэй хугацаатайгаар Монгол Улсын аль нэг арилжааны банкнаас гаргуулан Эрх бүхий этгээдэд ирүүлсэн байна.
- 1.18. Талууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурснаар Гэрээ байгуулагдсанд тооцогдох бөгөөд Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш **2** сарын хугацаанд дор дурдсан урьдчилсан нөхцөл бүрэн хангагдсанаар энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болно. Үүнд:
 - 1.18.1. Төслийн барилга угсралтын зардлын 5 хувьтай тэнцэх 25,340,365.38 /хорин таван сая гурван зуун дөчин мянга гурван зуун жаран таван юань гучин найман мо/ юаныг Монгол Улсын арилжааны аль нэг банкнаас дахь өөрийн дансанд байршуулж төслийн зориулалтын дагуу зарцуулж эхэлсэн байх;
 - 1.18.2. Авто замын хяналтын зөвлөх компанийн зардал 23,205,462.80 /хорин гурван сая хоёр зуун таван мянга дөрвөн зуун жаран хоёр юань наян мо/ юаныг Эрх бүхий этгээдийн заасан дансанд тушаасан байх;
 - 1.18.3. Барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байх /Монголын үндэсний аж ахуйн нэгжтэй барилгын ажлын 1/3-ээс доошгүй хувийн ажлыг гүйцэтгүүлэхээр барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байх/;
 - 1.18.4. Концесс эзэмшигч нь гадаадын аж ахуйн нэгж байгаа тохиолдолд, Монгол улсын хууль тогтоомжийн дагуу концесс

эзэмшигчийн 100 хувийн хөрөнгө оруулалттай компани /төсөл хэрэгжүүлэх нэгж/-ийг байгуулсан байх. Тус компани нь концесс эзэмшигчтэй адил тэгш эрх эдэлж үүрэг хүлээнэ.

- 1.19. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөл хангагдсан эсэх талаар Эрх бүхий этгээд дүгнэлт гаргана.
- 1.20. Энэхүү Гэрээний 1.19-д заасан дүгнэлт нь хангалтгүй гэж гарсан бол Эрх бүхий этгээд нь энэхүү гэрээг дангаар цуцлах эрхтэй.
- 1.21. Энэхүү Гэрээний 1.20-д заасан нөхцөлөөр гэрээг цуцалсан тохиолдолд эрх бүхий этгээд нь концесс эзэмшигчид ямар нэгэн нөхөн төлбөр болон хохирлыг төлөхгүй.
- 1.22. Концесс эзэмшигч нь энэхүү гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 12 сарын дотор төслийн санхүүжилтийн гэрээг Эрх бүхий этгээдэд ирүүлнэ.
- 1.23. Энэхүү гэрээний 1.17-д заасан баталгаа нь 1.22-д заасан нөхцөл биелэгдсэн тохиолдолд уг баталгаа нь цуцлагдана.
- 1.24. Энэхүү гэрээний 1.22-т заасан хугацаанд төслийн санхүүжилтийн гэрээг Эрх бүхий этгээдэд ирүүлээгүй тохиолдолд гэрээний 1.17-д заасан баталгаа нь үл маргах журмаар Эрх бүхий этгээдийн заасан дансанд шилжинэ.
- 1.25. Концесс эзэмшигч нь дараах үйл ажиллагааг Эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ. Үүнд:
 - 1.25.1. Концессын зүйлийг санхүүжүүлэх зорилгоор бусдад баталгаа гаргах;
 - 1.25.2. Концесс эзэмшигчийн дүрэм, үүсгэн байгуулах тухай шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ зэрэгт нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 1.25.3. Төслийн хөрөнгө оруулагч болон төслийн гүйцэтгэгчийг өөрчлөх;
 - 1.25.4. Концесс эзэмшигч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, эсхүл гүйцэтгэхгүй байж болзошгүй байдал үүссэнээс бусад тохиолдолд нэмэлт санхүүжилт авах;
 - 1.25.5. Төслийн санхүүжилтийн гэрээ, барилгын ажил гүйцэтгэх гэрээ, барилгын ажлын гэнэтийн ослын даатгалын гэрээ зэрэгт нэмэлт, өөрчлөлт орох бол.

Концессын зүйлийг шилжүүлэх үед тавигдах шаардлага

- 1.26. Энэхүү Гэрээний 1.7-д заасан хугацаанд концесс эзэмшигч нь төслийн авто замын барилгын ажлыг бүрэн дуусгаж холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу авто замыг хүлээн авах комиссоод хүлээлгэж өгнө.

- 1.27. Эрх бүхий этгээд нь зохицуулах байгууллагуудтай хамтран концессын зүйлийг хүлээн авах комиссыг энэхүү Гэрээний 1.7-д заасан хугацаа дуусахаас ажлын 45 хоногийн өмнө байгуулсан байна.
- 1.28. Концесс эзэмшигчийн төслийн авто замын барилгын ажлыг хүлээн авсан тухай актыг Эрх бүхий этгээд нь холбогдох зохицуулах байгууллагад нь хүргүүлнэ. Тухайн актыг эрх бүхий этгээдээс холбогдох зохицуулах байгууллагад хүргүүлэх үйл явц нь энэхүү гэрээний 1.10-д заасан эргэн төлөлтийн хуваарьт нөлөөлөхгүй

ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

Эрх бүхий этгээдийн эрх, үүрэг

- 2.1. Эрх бүхий этгээд нь батлагдсан зураг төслийн дагуу барилгын ажилд хяналт тавих хяналтын зөвлөх компани /цаашид “Зөвлөх” гэх/-ийг ажиллуулна.
- 2.2. Эрх бүхий этгээд нь концесс эзэмшигчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу ажиллах хүч, бараа материал, машин механизм, тоног төхөөрөмжийг хил, гаалиар нэвтрүүлэх, зөвшөөрөл авах зэрэг зохицуулах байгууллагуудтай хамтарч ажиллахад нь дэмжлэг үзүүлж болно.
- 2.3. Эрх бүхий этгээд нь концесс эзэмшигчийн авто замын барилгын ажил явагдах замын трассын дагуух газрыг ашиглах эрхийг барилгын ажлын хугацаанд олгоход нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.4. Эрх бүхий этгээд нь концесс эзэмшигчийн хүсэлтийн дагуу ажиллах хүчний зөвшөөрөл авахад нь зохицуулах байгууллагатай хамтарч ажиллахад нь дэмжлэг үзүүлж болно.
- 2.5. Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш зураг төслийн байгууллагаас концесс эзэмшигчид замын барилгын ажлын улаан шугам хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна.
- 2.6. Концесс эзэмшигчээс ирүүлсэн хүсэлт, мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хянан үзэж хариу мэдэгдлийг хүргүүлнэ.
- 2.7. Энэхүү Гэрээ байгуулагдсаны дараа төслийн санхүүжилтийн гэрээгээр зээлийн хүү буурсан тохиолдолд Эрх бүхий этгээд нь Гэрээний үнэ болон эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.
- 2.8. Эрх бүхий этгээд нь өөрийн бүрэн эрхийг энэхүү Гэрээ болон Концессын тухай хуульд заасны дагуу эдэлнэ. Эрх бүхий этгээд нь энэхүү гэрээг Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр гэрээ гэдгийг баталж байна.

- 2.9. Эрх бүхий этгээд нь концесс эзэмшигчийг зохицуулах байгууллагуудтай хамтарч ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 2.10. Эрх бүхий этгээд нь өөрийн бүрэн эрхийг энэхүү Гэрээ болон Концессын тухай хуульд заасны дагуу эдэлнэ.

Зохицуулах байгууллагын эрх, үүрэг

- 2.11. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь авто замын барилгын ажилд оролцох гадаадын инженер техникийн болон мэргэшсэн ажилчдыг Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх.
- 2.12. Тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд нь төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрөөс хамаарах аливаа асуудлуудыг цаг хугацаанд нь шийдвэрлэх үүрэгтэй.
- 2.13. Зохицуулах байгууллагууд нь аливаа тусгай зөвшөөрөл олгохдоо үндэслэлгүйгээр удаашруулж, саатуулж болохгүй.
- 2.14. Зохицуулах байгууллага нь Концессын тухай хуулийн 29.3-т заасны дагуу Концессын гэрээг байгуулснаас хойш тухайн газрыг ашиглах асуудлыг зохицуулах байгууллага зохих журмын дагуу нэн даруй шийдвэрлэх үүрэгтэй.
- 2.15. Холбогдох аймгийн Засаг дарга түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох асуудлыг зохих журмын дагуу нэн даруй шийдвэрлэх үүрэгтэй.

Концесс эзэмшигчийн эрх, үүрэг

- 2.16. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 1.7-дах заалтын дагуу авто замыг чанарын шаардлагын дагуу гүйцэтгэж, хугацаанд нь ашиглалтад оруулах үүрэг хүлээнэ.
- 2.17. Концесс эзэмшигч нь ажлын талбай дахь аливаа ажиллагаа, ажлын аргачлал болон нийт барилгын бүрэн дүүрэн гүйцэтгэл, бат бэх байдал, аюулгүй байдалд хариуцлага хүлээнэ.
- 2.18. Үйлдвэрлэлийн технологийн шаардлагад зохицсон, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах.
- 2.19. Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдийн шаардлагын дагуу барилгын ажлын гүйцэтгэлийн нарийвчилсан хуваарилалт, барилгын ажлын аргачлалыг гаргаж өгнө. Эрх бүхий этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр энэхүү хуваарилалт, аргачлалд өөрчлөлт хийхгүй.
- 2.20. Эрх бүхий этгээд болон Зөвлөхөөс Концесс эзэмшигчид хандан бичгээр гаргасан аливаа баримт бичиг, хүсэлтэд хариу илгээх шаардлагатай үед

Концесс эзэмшигч нь ажлын 10 хоногийн дотор бичгээр хариу мэдэгдэх (зөвшөөрсөн, эсвэл бусад аргачлалыг санал болгосон) ба хариу мэдэгдээгүй тохиолдолд концесс эзэмшигч нь зөвшөөрсөн буюу хүлээн авсан гэж үзнэ.

- 2.21. Концесс эзэмшигч нь Монгол улсад мөрдөгдөж буй аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөнө.
- 2.22. Авто замын барилгын ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор аливаа гуравдагч этгээд, туслан гүйцэтгэгчтэй хамтран ажиллах нь концесс эзэмшигчийг Эрх бүхий этгээдийн өмнө хүлээсэн аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөхгүй бөгөөд концесс эзэмшигч нь тэдгээрийн үйлдэл, эс үйлдлийн төлөө Эрх бүхий этгээдийн өмнө бүрэн хариуцлага хүлээнэ.
- 2.23. Концесс эзэмшигч өөрийн зардлаар байгаль орчин, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны бүхий л шаардлага, холбогдох хуулийн хэм хэмжээг бүрэн хангаж ажиллана.
- 2.24. Энэхүү гэрээнд зааснаар авто замын чанарын баталгаат хугацаанд авто замын урсгал засвар, арчлалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 2.25. Концесс эзэмшигч нь хийгдсэн ажлын гүйцэтгэлийг дүнг сар бүр, Зөвлөх, Эрх бүхий этгээдэд гаргаж өгнө.
- 2.26. Концесс эзэмшигч нь ус болон байгалын бусад нөөц ашигласны төлбөр, ажлын талбайн гадна талаас олборлож байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал, газар ашигласны төлбөр, түрээс, бусад хураамжийг төлнө.
- 2.27. Авто замын барилгын ажилд дотоодын ажиллах хүчийг их хэмжээгээр оролцуулах, гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн авч буй өндөр ур чадвар, нарийн мэргэшил шаардсан ажлын байранд дотоодын ажиллах хүчийг дагалдуулан ажиллуулж, мэргэшүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАРИЛГЫН АЖИЛ, ЗАСВАР АРЧЛАЛТ

- 3.1. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг барьж байгуулах болон засвар арчлалтыг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр хийж гүйцэтгэх ба 3 жилийн хугацаанд засварлаж арчлана.
- 3.2. Концесс эзэмшигч нь авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ холбогдох байгууллагаас баталсан барилгын норм норматив, стандартыг дагаж мөрдөнө.
- 3.3. Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээд эсхүл түүний томилсон аливаа төлөөний этгээдэд барилгын ажилтай холбоотой санхүүгийн бүртгэл, тайлан, барилга байгууламжид тавих техникийн хяналтын тайлан түүнчлэн Эрх бүхий этгээдийн тухайн үед үндэслэлтэйгээр шаардаж болох бүх мэдээлэл, тайлангуудыг гаргаж өгнө.
- 3.4. Эрх бүхий этгээд, зохицуулах байгууллага, Зөвлөх нь барилгын ажлын аль

нэг хэсэг, эсвэл хэсгүүдэд нь чанарын доголдолтой гэж үзэж байгаа бол барилгын ажлын ямар ч үед концесс эзэмшигчид үндэслэлтэй тайлбар бүхий мэдэгдэл өгч, тухайн хэсгийг нээж, шалгах шаардлага тавьж болох ба түүнийг концесс эзэмшигч биелүүлнэ.

- 3.5. Эрх бүхий этгээд, зохицуулах байгууллага, Зөвлөх нь барилгын ажлын холбогдох хэсгүүдэд үзлэг хийж, чанарын доголдолтой гэдэг нь тогтоогдсон бол концесс эзэмшигч өөрийн зардлаар бүх доголдлыг засаж залруулан, үүнтэй холбогдон гарсан бүх үр дүнг хариуцах бөгөөд барилгын ажлын хугацааг үүнтэй холбогдуулан сунгахгүй.
- 3.6. Концесс эзэмшигч нь төслийн газраас үнэт эсхүл хуучны эд өлгийн зүйлс, палеонтологи, археологийн олдвор олдвол тэр даруй ажлыг зогсоож Эрх бүхий этгээд болон орон нутгийн удирдлагад мэдэгдэж, тэдний зааварчилгааг биелүүлнэ. Концесс эзэмшигч нь тэдгээр олдворуудыг бусад этгээдүүд ашиглах, гэмтээхээс сэргийлэх шаардлагатай арга хэмжээг яаралтай авна. Уг ажилд зарцуулагдсан хугацааг концесс эзэмшигч нөхөж авах эрхтэй.
- 3.7. Концесс эзэмшигч нь авто замын чанарын баталгаат хугацаанд тухайн жилд гарсан технологийн эвдрэл гэмтлийг засаагүй тохиолдолд эрх бүхий этгээд нь концесс эзэмшигчид төлөх эргэн төлөлтөөс суутгаж авна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

- 4.1. Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.
- 4.2. Эрх бүхий этгээд нь авто замын барилгын ажилд хяналт тавих Зөвлөх томилон ажиллуулна.
- 4.3. Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь авто замын барилгын ажилтай холбогдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.
- 4.4. Концесс эзэмшигч нь Зөвлөхийн зардал болох эрх бүхий этгээдэд тушаасан төлбөрөөс гадуурх Зөвлөхтэй холбогдон гарах бусад зардлыг хариуцахгүй.
- 4.5. Концесс эзэмшигч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж Зөвлөхөөр батлуулна.
- 4.6. Ажлын хөтөлбөрийг тодотгохдоо үйл ажиллагаа бүрийн явц, үр дүн, тэдгээрийн үйлдэж буй ажлыг гүйцэтгэх хугацаанд үзүүлэх нөлөө болон үйл ажиллагааны дараалалд оруулсан аливаа өөрчлөлтийг тусгана.
- 4.7. Ажлын хөтөлбөрийг Зөвлөх батлах нь концесс эзэмшигчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

- 4.8. Эрх бүхий этгээдээс томилсон Зөвлөх нь барилгын ажлын явцад концесс эзэмшигчийн бүрэн хийж дууссан инженерийн бие даасан бүтцийн / далан, суурь, хучилт/ ажлуудад дунд хугацааны чанарын сорил хийж, тэнцсэний дараа Эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ. Концесс эзэмшигчийн бүрэн хийж дууссан инженерийн бие даасан бүтцийн ажил болон чанарыг баталгаажуулсны дараа дараагийн үе шатны ажилд орно.
- 4.9. Зөвлөх нь сар бүр Концесс эзэмшигчийн хийж дуусган туршилтад тэнцсэн ажлыг гарын үсэг зурж Эрх бүхий этгээдэд явуулах ба ингэснээрээ концесс эзэмшигчийн сар бүрийн барилгын ажлын гүйцэтгэл болон хийж дуусгасан ажлын чанар байдлыг баталгаажуулна.

Чанарын хяналт

- 4.10. Зөвлөх нь концесс эзэмшигчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар түүнд мэдэгдэнэ. Зөвлөх зөрчил, доголдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, доголдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах эрхтэй ба өрөмдлөг хийж дээж аван шалгалт туршилтад дэмжлэг үзүүлэх талаар зааварчилгааг концесс эзэмшигчид өгөх эрхтэй.
- 4.11. Зөвлөх аливаа зөрчил, доголдолтой эсэхийг шалгах зорилгоор техникийн тодорхойлолтод заагаагүй шалгалт туршилт явуулах зааварчилгааг концесс эзэмшигчид өгч, түүгээр зөрчил, доголдол илэрсэн бол концесс эзэмшигч шалгалт туршилт явуулсан зардлыг төлнө.
- 4.12. Зөвлөх чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг концесс эзэмшигчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил доголдлыг арилгаж дуусах хүртэл хугацаагаар сунгана.
- 4.13. Зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр концесс эзэмшигч уг зөрчил, доголдлыг Зөвлөхийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж концесс эзэмшигч нь өөрийн зардлаар арилгана.
- 4.14. Концесс эзэмшигч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Зөвлөх зөрчил, доголдол арилгахад шаардагдах зардлыг тооцож зөрчил доголдлыг арилгах тухай мэдэгдлийг Эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

Даатгал

- 4.15. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг Концессын тухай хуулийн 26.5-д заасны дагуу гэнэтийн ослын даатгалд хамруулж болно.
- 4.16. Энэхүү Гэрээний 4.15-д заасан даатгалын төрөлд даатгуулах үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан бүх зардал, эрсдэлийг концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр хариуцна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 5.1. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэж талуудын буруутай үйл

ажиллагаанаас шалтгаалаагүй, тэдгээрийн хүсэл зориг, хяналтаас гадуур бий болсон, урьдчилан харах боломжгүй буюу талууд өөрсдийн зүгээс зохих шаардлагатай арга хэмжээг авсан хэдий ч урьдчилан сэргийлэх боломжгүй байсан бөгөөд үүний улмаас талуудын үүргийн гүйцэтгэлд саад учруулсан нөхцөл байдлыг хэлнэ. Үүнд:

а. Үймээн самуун, дайн, халдан довтолох, гадаадаас дайсагнах ажиллагаа, дайн зарласан эсэхээс үл хамааран хийсэн байлдааны үйл ажиллагаа, терроризм буюу алан хядах ажиллагаа, иргэний дайн, бослого, хувьсгал, цэргийн болон бусад хүчийг ашиглан хийх эргэлт бослого, төрийн эрх мэдлийг татан буулгах буюу хүчээр шилжүүлэн авах;

б. Цацраг идэвхтэй бодисын тархалт, хордлого, цөмийн болон хорт бодис дэлбэрснээс үүдсэн цацраг идэвхт бодисын тархалт, цөмийн хог хаягдал зэргээс үүссэн бохирдол, бусад аливаа тэсэрч дэлбэрэх болон цөмийн эд материал бодисоос үүссэн аюултай нөхцөл;

в. Газар хөдлөлт, үер, гал түймэр болон бусад байгалийн гамшиг (үүнд үр дагавраар нь ямар байхаас үл шалтгаалан цаг агаарын байдлыг оруулахгүй);

г. Авто замын төслийн үйл ажиллагаа болон зурвас газрын ашиглалттай шууд холбоотой тухайлсан тодорхой асуудлаар үүссэн улс үндэстэн, нийтийг хамарсан ажил хаялт, аж үйлдвэрийн болон хөдөлмөрийн маргаан, эсвэл талууд болон тэдгээрийн гүйцэтгэгчид, бэлтгэн нийлүүлэгчдэд ажилладаггүй хөндлөнгийн этгээдийн зүгээс хийж буй ажил хаялт, хөдөлмөрийн маргаан;

д. Батлагдсан зураг төслийн дагуу тогтоосон Авто замын чигийг өөрчлөх хэмжээний ач холбогдолтой өмнө нь мэдэгдээгүй газар орчны нөхцөл байдал, археологийн олдвор болон байгалийн түүхийн эд өлөг шинээр илрүүлсэн;

е. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хил хаасан, авто замын харилцааг эхлүүлээгүй буюу зогсоосон.

5.2. Энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор бусад этгээдтэй байгуулсан гэрээ хэрэгжихгүй болсон аливаа тохиолдол нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйлд тооцогдохгүй.

5.3. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тухай Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн дагуу Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ (Force majeure certificate) болон Хүнд нөхцөл байдлын гэрчилгээ (Hardship certificate) авч баталгаажуулна.

Мэдэгдэл

5.4. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол энэхүү Гэрээний дагуу хүлээх эрх үүргээ биелүүлж чадаагүй буюу боломжгүй болж хойшлогдсон тал нь нөгөө талдаа давагдашгүй хүчин зүйлийн талаарх бүх мэдээлэл болон тухайн үйл

явдал нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон үндэслэлийн талаар нэн даруй мэдэгдэнэ.

Давагдашгүй хүчин зүйл дуусгавар болох

- 5.5. Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл дуусгавар болмогц тухайн ашиг сонирхол хөндөгдсөн тал аль болох бололцоотой хугацаанд энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг үргэлжлүүлнэ.
- 5.6. Давагдашгүй хүчин зүйл нь тухайн үйл явдал болохоос өмнө үүссэн хариуцлагыг хүлээх эсвэл тухайн үйл явдал болохоос өмнө хугацаа нь болсон төлбөрийн үүргээс чөлөөлөхгүй.

Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг өөрчлөх, цуцлах

- 5.7. Хэрэв гэнэтийн давагдашгүй хүчин зүйл нь 120 өдрөөс илүү хугацаагаар үргэлжлэх төлөвтэй хэмээн талуудын дүгнэж байгаа буюу үргэлжилж буй бол гэнэтийн давагдашгүй хүчний үргэлжлэх хугацаагаар, авто замыг барих боломжгүй болсон бол давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн үргэлжилсэн хугацаанаас багагүй хугацаагаар энэхүү Гэрээний хугацааг сунгана.
- 5.8. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс энэхүү Гэрээний хугацааг үргэлжлүүлэх, сунгах боломжгүй нөхцөлд давагдашгүй хүчин зүйлийн талаарх мэдэгдлийг хүргүүлснээс хойш 180 хоногоос багагүй хугацааны дараа аль нэг тал нь энэхүү Гэрээг цуцалж болно.

ЗУРГАА ДУГААР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ГЭРЭЭГ СУНГАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ХАРИУЦЛАГА

- 6.1. Концессын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу энэхүү Гэрээний хугацааг сунгах асуудлыг талууд харилцан тохиролцож сунгаж болно.
- 6.2. Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу талууд харилцан тохиролцож энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Концессын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү Гэрээ дуусгавар болох эсхүл цуцлагдана.
- 6.4. Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 1.7-д заасан хугацаанд концессын зүйлийг ашиглалтад оруулаагүй тохиолдолд ашиглалтад оруулах ёстой байсан өдрөөс хойш хугацаа хоцорсон хоног тутам дуусаагүй барилгын ажлын нийт үнийн дүнгийн 0.05%-ийн алданги Эрх бүхий этгээдэд төлнө. Эрх бүхий этгээд нь алдангийг концесс эзэмшигчид өгөх төлбөрөөс үл маргах журмаар суутган авна. Засгийн газар энэхүү гэрээний 1.10-т заасан эргэн төлөлтийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд концесс эзэмшигчид учирсан хохирлыг 3 сарын дотор бүрэн хариуцаж арилгана.
- 6.5. Төслийн санхүүжилт хуваарьт хугацаанаас 2 сарын хугацаагаар саатаж

авто замын барилга угсралтын ажил зогсоход хүрвэл Эрх бүхий этгээд нь төслийг хэрэгжүүлэхэд концесс эзэмшигчийн оруулсан бодит хөрөнгө оруулалтыг тодорхойлон тооцож энэхүү Гэрээг цуцлан дараагийн концесс эзэмшигчийг сонгох эрхтэй.

- 6.6. Шинээр сонгогдох концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 6.5-д заасан төсөлд оруулсан бодит хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.
- 6.7. Эрх бүхий этгээд, Зохицуулах байгууллага хууль тогтоомж, энэхүү Гэрээний дагуу хүлээсэн аливаа үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Концесс эзэмшигч төслийг хугацаа хоцорч биелүүлэх, авто замыг энэхүү Гэрээний 1.7-д заасан хугацаанд ашиглалтад оруулж амжихгүй зэрэг нөхцөл байдал үүсвэл Эрх бүхий этгээд энэхүү Гэрээний хугацааг Концесс эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр сунгана.
- 6.8. Хэрэв концесс эзэмшигч нь барилгын ажлын хугацаанд гэрээний үүргээ зөрчсөний улмаас гэрээг цуцлах тохиолдолд, концесс эзэмшигчийн төсөлд оруулсан бодит хөрөнгө оруулалтыг тооцож (зээлийн хүү болон хяналтын компанийн зардал багтана), гэрээг цуцалснаас хойш 6 сарын дотор концесс эзэмшигчид буцаан төлнө. Хэрэв талуудын хооронд буцаан төлөлттэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Концесс эзэмшигч Олон улсын бие даасан үнэлгээний компаниар төсөлд үнэлгээ хийлгэж буцаан төлөлтийг тогтоолгох эрхтэй.
- 6.9. Хэрэв концесс эзэмшигчээс шалтгаалахгүй нөхцөл байдлын улмаас Засгийн газар гэрээг цуцлах тохиолдолд, Концесс эзэмшигч нь Засгийн газраас энэ заалтад заасан нөхөн төлбөр төлөх болон төслийг хүлээж авахыг шаардах эрхтэй ба концессын гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын хэмжээ, гарсан зардал, тухайн талд учирсан хохирол, үүний дотор шаардлагатай тохиолдолд олох боломжтой байсан орлогыг тус тус тооцож гэрээ цуцалснаас хойш 6 сарын дотор концесс эзэмшигчид буцаан төлнө. Хэрэв талуудын хооронд нөхөн төлбөртэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд Концесс эзэмшигч Олон улсын бие даасан үнэлгээний компаниар төсөлд үнэлгээ хийлгэж нөхөн төлбөр тогтоолгох эрхтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Энэхүү Гэрээнээс үүдэн гарах аливаа маргааныг шийдвэрлэхдээ Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 7.2. Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийн хооронд аливаа маргаан үүсэх тохиолдолд талууд маргааныг эв зүйгээр шийдвэрлэхийг зорино.
- 7.3. Талууд маргааныг энэхүү Гэрээний 7.2-т зааснаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Сингапурын Олон Улсын Арбитраар ("SIAC") гуравдагч орны хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх ба арбитр явагдах газар нь Сингапур улс байна.

Ажлын тоо хэмжээ, төсөв энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна.

Энэхүү Гэрээг Монгол хэл дээр 6 хувь үйлдэж, Талууд 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: С. Жавхланбаатар

Албан тушаал: Хөрөнгө оруулалтын газрын дарга

Тамга:

ХАЯГ:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж-11,
Засгийн газрын 11-р байр,
8 давхарт



КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Жан Юун Зүнь /Zhang Yong Jun/

Албан тушаал: Ерөнхий захирал

Тамга:

ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо,
7-р хороолол, Алтайн гудамж-34,
контор үйлчилгээний зориулалттай барилга
8 давхар 807 тоот
Утас: 9583-3333

